



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 4/25

Номгон

Төсөл, хөтөлбөр, бодлого, стратегийг
хэрэгжүүлэх арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 90 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөл, хөтөлбөр, бодлого, стратегийг 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Төсөл, хөтөлбөр, бодлого, стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулах 300,000,000 (Гурван зуун сая) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3.Төсөл, хөтөлбөр, бодлого, стратегийг үр дүнтэй хэрэгжүүлж, танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын
13-ны өдрийн 4185 дугаар захирамжийн хавсралт

**ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, БОДЛОГО, СТРАТЕГИЙН
ЖАГСААЛТ**

		сая.төг
Д/д	Нийт дүн	300.0
1	2	3
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс		50.0
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	3
2	Цахим Баянхонгор арга хэмжээг хэрэгжүүлэх	10
3	Хөрш болон гуравдагч хөрш орнуудтай харилцаа тогтоох, хамтран ажиллах гадаад арга хэмжээ зохион байгуулах	37
Хууль, эрх зүйн хэлтэс		53.5
4	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх	8
5	"Ногоон бүс" төслийн ажлыг эрчимжүүлэх тухай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 7/25 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах	10
6	Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны А/18 дугаар захирамжаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх 2025-2028 оны бодлого, чиглэл"-ийг хэрэгжүүлэх	1
7	Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны А/645 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах талаар 2023-2027 онд баримтлах бодлого чиглэл"-ийг хэрэгжүүлэх	22.5
8	Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний А/157 дугаар захирамжаар батлагдсан "Төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалтад 2025-2029 онуудад баримтлах бодлого чиглэл"-ийг хэрэгжүүлэх	12
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс		70.0
9	Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг дэмжих зорилгоор хавар, намрын улиралд үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, үзэсгэлэн худалдаа гаргах асар майхныг нэмэгдүүлэх	10
10	Орон нутагт шаардлагатай салбарт дутагдалтай байгаа мэргэжилтнүүдийг бэлтгэх зардал	40
11	Бод малд зохиомол хээлтүүлэг хийх	10
12	Баталгаажсан үүлдэр омгийн малд шилэн сонголт хийх	10
13	Татвар төлөгчийн салбарын ангилал болон үйл ажиллагааны онцлогт нийцсэн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх замаар	10

1	2	3
Санхүү төрийн сангийн хэлтэс		15.0
14	Төсвийн татварын орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх	10.0
15	Төсвийн ил тод байдлыг хангах, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор "Иргэдийн төсөв"-ийг боловсруулан олон нийтэд хүргэх	5
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс		5.0
16	Туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах	5
Нийгмийн бодлогын хэлтэс		96.5
17	"Хонгорын хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлэх	25
18	НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сангийн төслийн үйл ажиллагааг дэмжих	8
19	"Хонгорын марафон" уралдаан зохион байгуулах	6
20	Оточ номгон өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн "Алтан 1000 хоног" зорилтот арга хэмжээ хэрэгжүүлж загвар гаргах	3.5
21	Хөдөө сумдад "Хамтын нэгдэл" соёл, урлагийн байгууллагуудын цогц соёлын үйлчилгээг хүргэх	15
22	Хөвгүүдийн клубийн гишүүдийг чадавхжуулан загвар клуб байгуулан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	3
23	"Одонтой ээжүүд" чуулган зохион байгуулах	6
24	Орон нутгийн амжилт гаргасан иргэдийг урамшуулах журмын хэрэгжилтийг хангах	25
25	Анхны тусламжийн нөхөрлөлүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	5
Цэргийн штаб		10.0
26	Орон нутгийн хамгаалалтын сургалт зохион байгуулах	10

___оОо___



وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس

وختسمنځنۍ سولېس مړ

وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس

وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس

وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس

وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس

وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس

وختسمنځنۍ سولېس مړ
لارېس مځنۍ لار لارېس



642501753